



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон-Чулуут голын сав газрын захиргаа 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/33/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2024 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Б. Азантунгалаг Утас: 92091017 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.17 № 18
танай _____-ны № _____-т

ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Ч.ОТГОНБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам" батлагдсаны дагуу нийт 46,121.5 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшуулалд олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, харуул, хамгаалалтын зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг гэсэн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 625,480.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 614,103.5

мянган төгрөгийг зарцуулж, 11,377.2 мянган төгрөгийн төсвийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Орхон-Чулуут голын сав газрын захиргаа нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж батлуулсан бөгөөд 30 арга хэмжээ нь дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүндээ хүрсэн, 2 арга хэмжээ 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Байгаль, орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлж 91.7 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,571,000.00	29,933,459.56
33	АВЛАГА	-	19,813,759.56
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,188,659.56
335	Бусад авлага	-	17,625,100.00
3351	Байгууллагаас авах авлага	-	17,625,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,571,000.00	10,119,700.00
351	Түүхий эд материал	-	6,950,200.00
3511	Тусгай зориулалттай материал	-	6,950,200.00
354	Хангамжийн материал	3,571,000.00	3,169,500.00
3542	Аж ахуйн материал	3,571,000.00	231,000.00
3543	Сэлбэг хэрэгсэл	-	380,000.00
3547	Бусад хангамжийн материал	-	2,558,500.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	567,009,432.90	517,560,917.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	567,009,432.90	517,560,917.33
392	Биет хөрөнгө	537,009,432.90	486,292,984.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	124,679,637.00	124,679,637.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,361,826.47)	(25,154,303.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	308,207,496.50	308,207,496.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,263,999.96)	(61,641,499.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	204,077,471.51	235,203,826.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(79,833,030.55)	(98,451,175.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,841,959.40	11,520,611.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,338,274.53)	(8,071,608.89)
393	Биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
39301	Програм хангамж	-	1,267,933.33
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	42,000,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	570,580,432.90	547,494,376.89
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	570,580,432.90	547,494,376.89
51	Засгийн газрын хувь оролцоо	570,580,432.90	547,494,376.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	30,000,000.00	30,000,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	540,580,432.90	517,494,376.89
5121	Өмнөх үеийн үр дүн	540,580,432.90	540,580,432.90
5122	Тайлант үеийн үр дүн		(23,086,056.01)
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	570,580,432.90	547,494,376.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	699,473,984.50	716,423,233.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	269,647,496.50	11,336,233.33
120	Нийтлэг татварын бус орлого	269,647,496.50	11,336,233.33
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	269,647,496.50	11,336,233.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,826,488.00	705,087,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	369,781,500.00	625,480,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	369,781,500.00	625,480,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,044,988.00	79,606,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,244,988.00	63,660,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	15,946,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	463,062,558.74	739,509,289.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,062,558.74	739,509,289.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,875,103.15	669,170,614.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,720,851.87	390,542,164.47
210101	Үндсэн цалин	172,489,529.37	177,347,040.44
210102	Нэмэгдэл	49,177,770.40	144,375,016.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,959,078.48	44,368,500.00
210104	Урамшуулал	2,094,473.62	24,451,607.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,155,033.73	49,010,337.00
210201	Тэтгэврийн даатгал	20,122,420.22	33,859,203.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,394,197.03	4,101,777.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,915,356.90	1,845,106.00
210204	Ажилгүйдлийн даатгал	478,839.12	1,769,813.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,244,220.46	7,434,438.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,942,599.41	16,590,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,205,364.41	1,102,600.00
210302	Түлш, халаалт	14,031,700.00	14,131,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,959,816.00	1,356,200.00
210304	Байрны түрээс	4,745,719.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	31,538,078.00	35,612,900.00
210401	Бичиг хэрэг	7,254,828.00	3,534,100.00
210402	Тээвэр, шатахуун	19,844,550.00	24,335,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,337,500.00	1,637,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,901,200.00	2,415,100.00
210408	Бараа материал акталсны зардал	80,000.00	3,571,000.00
2105	Нормативт зардал	12,624,624.00	52,400.00

210502	Хоол, хүнс	9,600,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,024,624.00	52,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,453,500.00	9,415,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,983,200.00	60,000.00
210602	Тавилга	2,800,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,200,000.00	313,800.00
210604	Урсгал засвар	18,470,300.00	9,041,300.00
2107	Томилолт, зочны зардал	25,639,238.00	37,531,100.00
210702	Дотоод албан томилолт	25,639,238.00	37,531,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,804,100.40	28,767,364.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,925,897.40	28,268,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	463,120.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,700.00	183,676.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,680.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	102,900.00	100,000.00
210807	Газрын төлбөр	69,803.00	59,888.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,997,077.74	101,648,748.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	965,007.00	3,049,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,876,000.00	9,359,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,156,070.74	89,239,548.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,187,455.59	70,338,674.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,187,258.00	58,961,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,187,258.00	12,840,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	46,121,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	197.59	11,377,174.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	197.59	11,377,174.97
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	236,411,425.76	(23,086,056.01)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	236,411,425.76	(23,086,056.01)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	429,826,488.00	705,087,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,826,488.00	705,087,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	369,781,500.00	625,480,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	369,781,500.00	625,480,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,044,988.00	79,606,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,244,988.00	63,660,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	15,946,000.00

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	429,826,488.00	676,632,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,826,488.00	676,632,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,626,290.41	606,293,525.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,457,300.00	392,730,824.03
210101	Үндсэн цалин	140,878,900.00	179,535,700.00
210102	Нэмэгдэл	64,915,100.00	144,375,016.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,100,000.00	44,368,500.00
210104	Урамшуулал	15,563,300.00	24,451,607.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,532,300.00	49,010,337.00
210201	Тэтгэврийн даатгал	21,145,600.00	33,859,203.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,346,800.00	4,101,777.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,877,200.00	1,845,106.00
210204	Ажилгүйдлийн даатгал	469,600.00	1,769,813.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,693,100.00	7,434,438.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,942,599.41	16,590,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,370,599.41	1,102,600.00
210302	Түлш, халаалт	14,131,700.00	14,131,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,856,200.00	1,356,200.00
210304	Байрны түрээс	4,584,100.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	30,690,378.00	31,616,900.00
210401	Бичиг хэрэг	7,014,228.00	3,534,100.00
210402	Тээвэр, шатахуун	19,844,550.00	24,335,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,337,500.00	1,637,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,374,100.00	1,990,100.00
2105	Нормативт зардал	10,852,400.00	1,252,400.00
210502	Хоол, хүнс	9,600,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,252,400.00	1,252,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,027,800.00	29,534,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,210,700.00	645,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,346,800.00	1,346,800.00
210604	Урсгал засвар	18,470,300.00	27,542,400.00
2107	Томилолт, зочны зардал	25,639,238.00	37,531,100.00
210702	Дотоод албан томилолт	25,639,238.00	37,531,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,338,375.00	31,162,364.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,435,172.00	30,663,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,800.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,700.00	183,676.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	65,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	127,900.00	100,000.00
210807	Газрын төлбөр	69,803.00	59,888.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,145,900.00	16,864,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,861,000.00	6,679,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,284,900.00	10,184,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,200,197.59	70,338,674.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,200,000.00	58,961,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,200,000.00	12,840,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		46,121,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	197.59	11,377,174.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	197.59	11,377,174.97

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		28,454,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		28,454,800.00
	Дотоод эх үүсвэрээр		28,454,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		28,454,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(28,454,800.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,000,000.00		304,169,007.14	334,169,007.14
2	Тайлант үеийн үр дүн			236,411,425.76	236,411,425.76
3	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,000,000.00		540,580,432.90	570,580,432.90
4	Тайлант үеийн үр дүн			-23,086,056.01	-23,086,056.01
5	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,000,000.00		517,494,376.89	547,494,376.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	625,480,700.00	614,103,525.03	11,377,174.97	98.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	625,480,700.00	614,403,525.03	11,077,174.97	98.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	574,359,200.00	563,282,025.03	11,077,174.97	98.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	372,851,500.00	363,889,742.03	8,961,757.97	97.6
210101	Үндсэн цалин	179,535,700.00	179,535,700.00		100
210102	Нэмэгдэл	117,421,200.00	115,533,934.92	1,887,265.08	98.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,368,500.00	44,368,500.00	-	100
210104	Урамшуулал	31,526,100.00	24,451,607.11	7,074,492.89	77.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,606,400.00	44,191,119.00	2,415,281.00	94.82
210201	Тэтгэврийн даатгал	31,692,300.00	30,590,440.00	1,101,860.00	96.52
210202	Тэтгэмжийн даатгал	3,728,500.00	3,728,500.00		100
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,864,300.00	1,651,292.00	213,008.00	88.57

210204	Ажилгүйдлийн даатгал	1,864,300.00	1,561,647.00	302,653.00	83.77
210205	Эрүүл мэндийн даатгал	7,457,000.00	6,659,240.00	797,760.00	89.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,590,600.00	16,590,500.00	100	100
210301	Гэрэл, цахилгаан	1,102,600.00	1,102,600.00		100
210302	Түлш, халаалт	14,131,700.00	14,131,700.00		100
210303	Цэвэр, бохир ус	1,356,200.00	1,356,200.00		100
210304	Байрны түрээс	100		100	
2104	Хангамж, бараа материалын зардал	25,887,900.00	25,887,900.00		100
210401	Бичиг хэрэг	2,335,100.00	2,335,100.00		100
210402	Тээвэр, шатахуун	19,805,200.00	19,805,200.00		100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,637,500.00	1,637,500.00		100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00		100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,990,100.00	1,990,100.00		100
2105	Нормативт зардал	1,252,400.00	1,252,400.00		100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,252,400.00	1,252,400.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,254,700.00	51,554,700.00	(300,000.00)	100.59
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,365,500.00	22,665,500.00	(300,000.00)	101.34
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,346,800.00	1,346,800.00		100
210604	Урсгал засвар	27,542,400.00	27,542,400.00		100
2107	Томилолт, зочны зардал	15,068,600.00	15,068,600.00		100
210702	Дотоод албан томилолт	15,068,600.00	15,068,600.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,937,200.00	30,937,164.00	36	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,438,600.00	30,438,600.00		100
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00		100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,700.00	183,676.00	24	99.99
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00		100

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	100,000.00		100
210807	Газрын төлбөр	59,900.00	59,888.00	12	99.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,909,900.00	13,909,900.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,725,000.00	3,725,000.00		100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,184,900.00	10,184,900.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,121,500.00	51,121,500.00		100
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,121,500.00	51,121,500.00		100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		5,000,000.00	(5,000,000)	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	46,121,500.00	46,121,500.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00		5,000,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		(300,000.00)	300,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		(300,000.00)	300,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		614,103,525.03	(614,103,525.03)	
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		614,103,525.03	(614,103,525.03)	
131001	Улсын төсвөөс санхүүжих		614,103,525.03	614,103,525.03	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14	14		100
6	Удирдах ажилтан	9	9		100
7	Гүйцэтгэх ажилтан	9	9		100
8	Үйлчлэх ажилтан	2	2		100
9	Гэрээт ажилтан	2	2		100
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	14	14		100
25	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10		100
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2		100
34	Гэрээт ажилтан	2		2	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	79,606,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,646,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,806,300.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,841,082.00
210102	Нэмэгдэл	28,841,082.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,819,218.00
210201	Тэтгэврийн даатгал	3,268,763.00
210202	Тэтгэмжийн даатгал	373,277.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	193,814.00
210204	Ажилгүйдлийн даатгал	208,166.00
210205	Эрүүл мэндийн даатгал	775,198.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,729,000.00
210401	Бичиг хэрэг	1,199,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,530,000.00
2107	Томилолт, зочны зардал	22,462,500.00
210702	Дотоод албан томилолт	22,462,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,954,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,954,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,840,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,840,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,840,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	960,000.00
	Дотоод эх үүсвэрээр	960,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	79,606,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	79,606,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,660,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,946,000.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **33,943.5** мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- ✓ Аж ахуйн материал дансанд 1,900.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 тавиур, 1,810.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байгааг үндсэн хөрөнгөөр бүртгэн залруулсан.
- ✓ Аудитаар 25 нэр төрлийн 10,419.7 мянган төгрөгийн аж ахуйн материалыг шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ✓ Аудитаар нийгмийн даатгал руу 2,188.7 мянган төгрөг илүү шилжүүлснийг авлагаар бүртгүүлээ. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ✓ Аудитаар Цогт нинжин ХХК-иас 17,625.1 төгрөгийн вакуум цонх хийлгэх гэрээ байгуулсан боловч ажил хийгдээгүй байгаа тул авлагаар бүртгүүлээ. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар залруулаагүй 6,696.2 мянган төгрөгийн зөрчил² илэрч 6,696.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 5 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 8 зөрчилтэй асуудлын 41,747.2 мянган төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг бусаар, 6,696.2 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг алдаагаар тооцсон ба материаллаг зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 7,036.7 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлттэй дүгнэлт** өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын" хүрээнд албан хаагчдад олгосон урамшууллаас 4,612.2 мянган төгрөгийг татвар суутгаж төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Ажилчдын албан хэрэгцээнд 1,800.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3 Томилолтын зардлаас 2023 оны анхан шатны баримтыг үндэслэн 284.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 12 сарын 16-ны өдрийн А/880 дугаар тушаалаар 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан дарга, нягтлан бодогчид цалингийн сангаас 3,522.2 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Өгийнуурын сургалт мэдээллийн төвийн байранд урсгал засварын зардлаас 17,625.1 мянган төгрөгийн хаалга, вакум цонх хийлгэх гэрээ байгуулсан боловч ажил бүрэн хийгдээгүй, тухайн байгууллага хүлээж аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 2 гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардалд 20,288.1 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.4. Бараа үйлчилгээний бусад зардлаас гэрээт ажилтны цалинд 284.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.5. Аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 29-ны өдрийн А/822 дугаар захирамжаар олгосон 1200 м.кв газрыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдаа ны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр / Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аж ахуйн материал дансанд 1,900.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 тавиур, 1,810.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй	1	1,810.0			1	1,810.0	1	1,810.0
Аудитаар 25 нэр төрлийн 10,419.7 мянган төгрөгийн аж ахуйн материалыг шууд зардалд бүртгэсэн байна.	1	10,419.7			1	10,419.7	1	10,419.7
Аудитаар нийгмийн даатгал руу 2,188.7 мянган төгрөг илүү шилжүүлснийг авлагаар бүртгүүлээ.	1	2,188.7	1	2,188.7			1	2,188.7
Аудитаар Цогт нинжин ХХК-иас 17,625.1 төгрөгийн вакуум цонх хийлгэх гэрээ байгуулсан боловч ажил хийгдээгүй байгаа тул авлагаар бүртгүүлээ.	1	17,625.1	1	17,625.1			1	17,625.1
Нийт дүн	4	32,043.5	2	19,813.8	2	12,229.7	4	32,043.5

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр / Үүнээс	
		Төлбөрийн акт	Албан шаардлага

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөө орон нутагт суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллаас 4,612.2 мянган төгрөгийн татвар суутгаагүй.	1	4,612.2	1	4,612.2		
Томилолтын зардлаас 2023 оны анхан шатны баримтыг үндэслэн 284.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	1	284.0	1	284.0		
Ажилчдын албан хэрэгцээнд 1,800.0 мянган төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авсан байна.	1	1,800.0	1	1,800.0		
Албан хаагчдад 3,522.2 мянган төгрөгийн урамшуулал буюу шагналыг цалингийн сангаас олгосон байна.	1	-			1	-
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 2 гэрээт ажилтны цалин, НДШ-ийн зардалд 20,288.1 мянган төгрөг зарцуулсан байна. .	1	-			1	-
Бараа үйлчилгээний бусад зардлаас гэрээт ажилтны цалинд 284.8 мянган төгрөг зарцуулсан байна.	1	-			1	-
Өгийнуурын сургалт мэдээллийн төвийн байранд урсгал засварын зардлаас 17,625.1 мянган төгрөгийн хаалга, вакум цонх хийлгэх гэрээ байгуулсан боловч ажил бүрэн хийгдээгүй, авлага үүссэн байна.	1	-			1	-
Аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 29-ны өдрийн А/822 дугаар захирамжаар олгосон 1200 м.кв газрыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.	1	-			1	-
Нийт дүн	8	6,696.2	3	6,696.2	5	-